

ХҮРЭЭ БАРЫН ГАНЖУУРЫГ БҮТЭЭСЭН ТУХАЙ

Телеки Кристина

Өтвөш Лорандын нэрэмжит их сургууль, Будапешт

Compilation of the Urga Kanjur: The Urga Kanjur is one of the most valuable written products of Urga. The Eighth Bogd Jawzandamba Khutagt (1870–1924) initiated its compilation at the beginning of the 20th century (1908–1910). It was written in Tibetan and consists of 105 volumes in smaller size than the other Kanjur editions. The text is a revised and corrected reprint of the Derge Kanjur. At present four sets are known, the one presented as gift to Raghu Vira was published in the Śata-piṭaka Series. Géza Bethlenfalvy compiled the catalogue of the Urga Kanjur in 1980 including an article of Lokesh Chandra that provides the text, the transcription, and the English translation of the table of contents (*garchig*, Tib. *dkar chag*). Among other topics, this *garchig* includes the history of the Urga edition naming its donators, revisers, carvers, and other attendants. The aim of the present paper is to introduce this large-scaled project. It turns out that several monks with *gawj* philosophical degree worked on the corrections under the guidance of Luwsanpuntsog, the head abbot of Urga. The people in charge of the printing procedure were mostly fully-ordained monks. Among the donators and revisers several famous monks and other historical figures are listed.

Хүрээ барын Ганжуурын товч түүх

Хүрээ барын Ганжуур нь төвдөөр бичигдсэн хэдий боловч Монголын бурханы шашны чухал үнэ цэнэтэй бүтээлүүдийн нэг юм. 20-р зууны эхэн үеийн Их хүрээний түүх, түүн дотроо Монголын бурханы шашны хөгжил өндөр түвшинд хүрсэн байсныг харж болохоор байна. Уг Ганжуурыг 8-р Богдын зарлигаар 1908–1910 оны хооронд бүтээсэн. Өөрөөр хэлбэл, түүхэндээ Бурхан багшийн айлдварыг төвд хэлээр модон бараар барласан хамгийн сүүлчийн бүтээл болон үлджээ.⁴⁴⁷

Хүрээ барын Ганжуур нийт 105 боть. Бусад Ганжууруудаас ялгагдах гол онцлог нь хамгийн бага хэмжээтэй (60×10/11см; хүрээ: 50×7,5см). Тухайн үеийн хүрээний эрдэмтэн лам нар Дэргэ Ганжуур (1733 он) ба Бээжин Ганжуур (1718–1720 он) болон бусад Ганжууруудыг хооронд нь харьцуулж нягтлаад, зарим судрыг хасаж, нэмэн 20-р зууны эхээр Их

⁴⁴⁷ Хүрээ барын Ганжуурын тухай англи хэлээр Teleki, K.: *Introduction to the Study of Urga's Heritage*. Mongolian Academy of Sciences, Institute of History and Archaeology – International Association for Mongol Studies. Ulaanbaatar 2015, т. 330–335. Хүрээ барын Ганжуурын судалгааг ОТКА PD83465 ба Bolyai János Kutatási Ösztöndíj ивээн тэтгэсэн.

хүрээнд Дэргэ Ганжуурыг нэмж засварласан нэгэн хувилбарыг бэлэн болгосон байна.⁴⁴⁸

Хүрээ барын Ганжуурын модон бар нь өнөө бидний үед үлдэж хоцорсонгүй. Хэдэн хувь хэвлэсэн тухай тодорхой баримт алга байна. Магадгүй Үндэсний Төв Архивт үүний талаар баримт байж болох юм. Хүрээ барын Ганжуур нь бүрэн бүтнээрээ одоогийн байдлаар Монгол улсын Үндэсний Номын Сан, Дамдинсүрэнгийн гэр музей, Улаан-Үд хотод ба Энэтхэг улсын Шинэ Дэли хотод хадгалагдаж байна. Энэтхэгийн хувийг БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн тэргүүлэгч Ю.Цэдэнбал 1955 онд Энэтхэгийн эрдэмтэн Рагу Вира-д бэлэглэсэн байна. Үүнийг 1960-аад оны орчим хэвлэж гаргаснаар дэлхийн олон орны номын сангуудад тараагдаж эрдэмтэн судлаачдад уншиж судлах боломжийг нээж өгчээ.⁴⁴⁹ Мөн 2017 онд Энэтхэг улсын ерөнхий сайд Санкт-Петербург хотын Гунзэчойнэй дацанд тухайн Ганжуурын шинэ хэвлэлийг бүтнээр бэлэглэсэн нь Хүрээ барын Ганжуурын чухал байхыг харуулна.

Хүрээ барын Ганжуурын гарчиг

Энэтхэгт хадгалж буй Хүрээ барын Ганжуурын хамгийн сүүлийн, 105-р ботийн эцэст байх 76 фолиотой гарчгийг (тө. *dkar chag*)⁴⁵⁰ Локеш Чандра 1905 онд латин үсэг рүү хөрвүүлэн гаргаж, англи хэлэнд орчуулсан.⁴⁵¹ Үүнийг Хүрээ барын Ганжуурын каталог бүтээсэн Бетленфалви Геза ч каталогтаа оруулсан.⁴⁵² Тухайн гарчиг нь үндсэн 4 хэсгээс бүтнэ: 1. Ганжуурын ерөнхий түүх, 2. Монгол бурханы шашны түүх, 3. Хүрээ барын Ганжуурын түүх, 4. Хүрээ барын Ганжуурын судруудын гарчиг (тө. *them byang*).⁴⁵³ Энэхүү судруудын гарчгийг 1980 онд Бэтлэнфалви Геза олны хүртээл болгосон.⁴⁵⁴ Мөн тухайн Ганжуурыг “20-р зууны эхэн үеийн Их хүрээний эрдэмтэн лам нарын өндөр түвшний боловсролын сайхан жишээ баримт” гэж дурдсан байна.⁴⁵⁵ Доор нь Хүрээ барын Ганжуурыг гарчгийн 3-р хэсэг буюу Хүрээ барын Ганжуурыг бүтээсэн тухай хэсэг

⁴⁴⁸ Bethlenfalvy, G.: *A Catalogue of the Urga Kanjur in the Prof. Raghuvira Collection at the International Academy of Indian Culture*. (Śata-piṭaka Series 246) International Academy of Indian Culture, New Delhi 1980, т. 4.

⁴⁴⁹ Lokesh Chandra (ed.): *Urga Kanjur*. Vols. 1–105. (Śata-piṭaka Series 396–500) International Academy of Indian Culture and Aditya Pakashan, New Delhi 1900–1994.

⁴⁵⁰ Lokesh Chandra (ed.): *Urga Kanjur*. Vols. 104–105. (Śata-piṭaka Series, 499–500) International Academy of Indian Culture and Aditya Pakashan, New Delhi 1994.

⁴⁵¹ Lokesh Chandra: A Newly Discovered Urga Edition of the Tibetan Kanjur. *Indo-Iranian Journal* 3. New Delhi 1959, т. 175–204.

⁴⁵² Bethlenfalvy, G.: *A Catalogue of the Urga Kanjur*, т. 291–319.

⁴⁵³ Bethlenfalvy, G.: *A Catalogue of the Urga Kanjur*, т. 4, 14.

⁴⁵⁴ Bethlenfalvy, G.: *A Catalogue of the Urga Kanjur*.

⁴⁵⁵ Bethlenfalvy, G.: *A Catalogue of the Urga Kanjur*, т. 4.

хэсгийн орчуулгаар танилцуулах болно.⁴⁵⁶

Хандив өргөсөн лам нар, ноёд, буяны садангууд

Хүрээ барын Ганжуур бүтээхийг Бурхан багшийн айлдварыг дэлгэрүүлэхийн тулд 8-р Богд Жавзандамба хутагт болон Эрдэнэ Цэцэн ноён Дондовлхам нар санаачилсан байна (fol. 247).⁴⁵⁷ Түүнээс гадна Эрдэнэ шанзодва Бадамдорж, Хүрээний бусад тушаалтнууд, Халхын дөрвөн аймгийн хаад, ноёд, мяндаг тушаалтан лам нар, хутагтууд, гавж, гэлэн, сүсэгтнүүд Ганжуурыг бүтээхэд хандив, хадаг, мөнгө өргөн барьжээ. Мяндаг тушаалтнуудын дотор 20-р зууны эхэн үеийн алдартай лам, хар хүмүүс байсан. Жишээ нь, Эрдэнэ шанзодва Г.Бадамдорж, Хамба номон хан Лувсанпунцаг (томилолт: 1900–1920), Хүрээний дэд хамба Намхай (1900–1910) ба Сономдаржаа (1910–1920), цорж, даа лам нар. Мөн Дарба бандид Агваанчойнжирдондүв (1870–1927) Хүрээ барын Ганжуурыг бүтээхэд голлох үүрэгтэй оролцжээ. Халхын 4 аймгийн ноёд, сүсэгтэн олны өргөсөн өргөл тун тодорхой бичигдсэн байна. Мөн Хүрээний унзад, нярав, гонир, гэлэн, гавж нар хадаг, мөнгө зоос хичнээн “лан” хандив болгон өргөсөн тоо баримт тодорхой байна. Үүний дотор нэгэн сонирхолтой баримт байгаа нь Пунцаг бичгийн цаас өгсөн тухай тэмдэглэсэн байна. Иймээс хүн бүр өөр өөрсдийн хэр хэмжээгээр Ганжуур бүтээхэд оролцжээ гэж үзэж болохоор байна. Үүнд (fol. 247):⁴⁵⁸

“Богд Жавзандамба хутагт ба Эрдэнэ Цэцэн ноён Дондовлхам: 11000 лан мөнгө (тө. *dnᠭul srang*)⁴⁵⁹

Эрдэнэ шанзодва Бадамдорж

Халхын дөрвөн аймгийн хаад, ноёд

Хамба номон хан Лувсанпунцаг: хадаг (тө. *bsod btags*) 1, 10 лан мөнгө

Дэд хамба Намхай: хадаг 1, торго (тө. *gos chen gos ldang*) (fol. 248)

Дэд хамба Сономдаржаа: вандан хадаг 10 (тө. *rnam dbang*)

Эрдэнэ шанзодва Бадамдорж: хадаг 1, 28 лан мөнгө

Гачин цорж Балданданзан: торго, 70 лан мөнгө

Лувсандондов цорж: 10 лан, 1 цэн (тө. *zho*) мөнгө

Найдан цорж: хадаг 1, 3 лан, 5 цэн мөнгө

⁴⁵⁶ Lokesh Chandra: *Urga Kanjur* Vols. 104–105. ff. 246–256.

⁴⁵⁷ Lokesh Chandra (ed.): *Urga Kanjur* Vols. 104–105.

⁴⁵⁸ Lokesh Chandra (ed.): *Urga Kanjur* Vols. 104–105. Мөн Bethlenfalvy, G.: *A Catalogue of the Urga Kanjur*, т. 291, 308.

⁴⁵⁹ Жагсаалт нь доорх төрөл төрлийн мөнгийг дурдаж байна: *dnᠭul srang* (“мөнгөн зоос,” энд лан = 37.3 грамм гэж орчуулагдана), *dnᠭul zho* (*dnᠭul srang*-ийн 10-ны нэг, энд нэг лангийн 10-ны нэг буюу цэн = 3.8 грамм гэж орчуулагдана), *skar ma* (*dnᠭul srang*-ийн 100-ны нэг хувь, энд пун = 0.731 грамм гэж орчуулагдана.)

Чойжиринчендондов: хадаг 1, 3 лан, 5 цэн мөнгө
Эрдэнэ хувилгаан: хадаг 1, 3 лан, 5 цэн мөнгө
Дарва бандид бүрэлгүү: нэг ботийг хэвлүүлсэн
(тө. pusta ka gcig gi par bzengs)
Даа лам Дашжав: хадаг 1, 5 лан мөнгө
Даа лам Цэрэнчимэд: хадаг 1, 5 лан мөнгө
Амбан бэйс Пунцагцэрэн: хадаг 1, 100 лан мөнгө
Намсрай гүн: хадаг 1, 24 лан, 4 цэн мөнгө
Жонан тайж: хадаг 1, 14 лан мөнгө
Түшээ гүн Шагдар: хадаг 1, 100 лан мөнгө
Шүхэр (тө. shu hur) гүн: 50 лан мөнгө
Гүртэн Хишигжаргал, хатан Ичинхорлоо: 50 лан мөнгө
Баруун хүрээний шүн (тө. gzhung): 30 лан, 5 цэн мөнгө
Түшээт хан аймгийн ард түмэн: ойролцоогоор 1666 лан мөнгө
Цэцэн хан аймгийн ард түмэн: ойролцоогоор 2150 лан мөнгө
Засагт хан аймгийн ард түмэн: ойролцоогоор 2056 лан мөнгө (fol. 249)
Сайн ноён хан аймгийн ард түмэн: ойролцоогоор 2150 лан мөнгө
Эрдэнэ унзад Чимэд: хадаг 1, торго
Лувсандаш нярав: ойролцоогоор 3 лан мөнгө
Дондог нярав: цагаан хадаг 10
Агваан гэлэн: 7 цэн, 5 пун мөнгө
Дашзэвэг: 2 лан, 2 цэн мөнгө, хадаг 1
Лувсандаш: ойролцоогоор 2 лан мөнгө
Дондов: ойролцоогоор 1 лан мөнгө
Бор гэлэн: 27 лан мөнгөнөөс бага
Дорж: 7 лан, 1 цэн мөнгө
Найдансүрэн: 7 пун мөнгө
Дондовдорж: 7 пун мөнгө
Гомбосүрэн: 50 лан мөнгө
Лувсанжимба: 7 пун мөнгө
Жадамба: 2 лан мөнгө, хадаг 1
Самдан гавж: 1 лан, 5 цэн мөнгө
Дорж: цагаан хадаг 5
Цэрэндулам: 7 цэн, 5 пун мөнгө
Пунцог: барлах цаас (тө. par gyi shog bu) 90 ширхэг
Агваанжав гэлэн: 1 пун мөнгөнөөс илүү
Балдандорж гэлэн: 1 пун мөнгөнөөс илүү
Намдал: 4 цэн, 4 пун мөнгө
Самбуу: цагаан хадаг 5 (тө. gnam dkar)
Цэвээн: 5 цэн мөнгө

Юлхорсүрэн: 3 цэн, 5 пун мөнгө
Пагжийвуу: 1 цэн мөнгөнөөс илүү
Шийлэгмаа: 1 цэн мөнгөнөөс илүү
Батнасан: 1 цэн мөнгөнөөс илүү
Сэрээтэр: 1 цэн мөнгөнөөс илүү
Дарьжав: 1 цэн мөнгөнөөс илүү
Дэжинмаа: 1 цэн мөнгөнөөс илүү
Цэрэндэжид: 1 цэн мөнгөнөөс илүү
Аюуш: 1 цэн мөнгөнөөс илүү
Цэрэндэжид: 1 цэн мөнгөнөөс илүү
Дулмаа: 1 цэн мөнгөнөөс илүү
Цэдэнжав: 1 цэн мөнгөнөөс илүү (fol. 250)
Сандаг: 1 цэн мөнгөнөөс илүү
Дунмаахүү: 1 цэн мөнгөнөөс илүү
Лувсаниш гэлэн: 1 цэн мөнгөнөөс илүү
Лувсанцүлтэм: 1 цэн мөнгөнөөс илүү
Лувсандамдин: 1 цэн мөнгөнөөс илүү
Дамдинжав: 1 цэн мөнгөнөөс илүү
Цэвэгдорж: 1 цэн мөнгөнөөс илүү
Ринчен: 1 цэн мөнгөнөөс илүү
Сономжид: 1 цэн мөнгөнөөс илүү
Янжин: 1 цэн мөнгөнөөс илүү
Лувсандампил гэлэн: хадаг 1
Ламжав: хадаг 1
Лувсандулам: хадаг 1
Дашням гонир: 2 лан мөнгөнөөс илүү
Цэвэгмэд гонир: 3 лан, 5 цэн мөнгө.”

Хэвлэлийг ивээн тэтгэгчид

Ганжуурыг өглөгийн эзэн болж барласан хүмүүс

(тө. sdon bsgrubs pa'i rag gnams ni):

“Түшээт хан: Ка, 1 боть
Дайчин чин ван: Ка, 4 боть
Цэцэн хан: 1 боть
Жалханз [хутагт]: 1 боть
Дайчин жүн (?) ван: 3 боть
Цэцэн жонон засаг: 1 боть
Ахай гүн: 1 боть
Егүзэр лам: 1 боть
Лхаван бэйс: 1 боть

Ялгуусан хутагт: 1 боть
Гомбожав засаг: 1 боть
Засагт хан: 1 боть
Бишрэлт ван: 1 боть
Дайчин бэйс: 1 боть
Төгс гүн: 1 боть
Дайчин гүн: 1 боть
Сид гүн: 1 боть
Аюур гүн: 1 боть
Сартуул гүн: 1 боть
Загар (тө. tsa kra) гүн: 1 боть
Түшээ гүн Галданпил (тө. dga' ston 'phel): 1 боть
Сайн ноён [хан]: 1 боть
Зая бандид: 1 боть
Цэцэн ван: 1 боть
Далай бэйл: 1 боть
Илдэн бэйл: 1 боть
Санчир (тө. sanggha srī) ван ба Цэрэнгомбо засаг: 1 боть
Цэдэнпэлжээ гүн ба Ноён хутагт: 1 боть (fol. 251)
Далай гүн: 1 боть
Равдандорж гүн: 1 боть
Авирмэд гүн: 1 боть
Мэргэн засаг: 1 боть
Манибадар засаг: 1 боть
Үржин гүн: 1 боть
Эрдэнэ бандид: 1 боть
Цэцэн бэйл: 3 боть
Жонон бэйс: 2 боть
Хардал бэйс: 2 боть
Далай бэйс: 3 боть
Түшээ гүн Жамсран: 2 боть
Ичинноров гүн: 1 боть
Дайчин засаг: 1 боть.”

Харьцуулж нягтлахад ажилласан лам нар

Ганжуурыг бүтээхийг чухалчлан авч үзвэл төвд Ганжууруудыг харьцуулж нягтлах ажлыг (тө. zhus dag) “Богд жавзандамба хутагт, Хамба номон хан тэргүүтэй Хүрээний цорж нарын ивээл дор Дарба бандид гавж Агваанчойнжирдондүв, Дамдинсүрэн гавж, Самдан гавж, Шарав агримба, Дамбадаржаа гавж, Дамбадаржаа гавж, Ёндон гавж, Цэрэндорж гавж,

Самдан гавж, Сандуйжав гавж, Дагдан гавж, Жимба гавж, Дамбадаржаа гавж, Арьябазар гавж, ба олон зуун гавж, гэвш нар хийж Нартан, Бээжин барын Ганжуурыг харьцуулж, нягтлан бүтээжээ.”

Барлах үйл явцыг хариуцагчид

Барлах үйл явцыг хариуцсан (тө. do dam byed pa po gnams) 13 хүний дотор Цогчин 4 гэсгүй, зайсан, нярав (тө. gnyer pa), дарга нарыг дурдаж болно. Мөн 3 жил зун, өвөлгүй тасралтгүй гээг (тө. dge g.yog), замчин (тө. ja ma), усч, мод зөөж авч ирдэг хүмүүсийг ч мартаж болохгүй юм. Үүнд:

“гэсгүй шадар Лувсангунгаатаяа
гэсгүй хичээнгүй Цанжид (fol. 252)

гэсгүй шадар Ёндон

гэсгүй Пунцаг гавж

зайсан нярав Дорж

Жунай нярав

Дондов нярав

Лувсандондов дарга

Ламжав дарга

Сэрээтэр дарга

Жамьян дарга

Дамчаа дарга

Нямбуу дарга гэх мэт гээг нар, замчин Цогт, түлээ, ус авч ирдэг бусад лам нар.”

Барыг хариуцдаг лам нар

Барыг хариуцдаг лам нар (тө. pag dpon) нь гэлэнгүүд байжээ. “Лувсанбалдан гэлэн, Раднаа гэлэн, Дагва гэлэн, Бум гэлэн, Гомбожав гэлэн, Бат, Ламжав, гэх мэт.”

Үсэг бичих лам нар

Модон бар дээр үсгийг бичихэд (тө. pag yig bris pa po) ч гэлэнгүүд идэвхийлэн оролцжээ. Үүнд:

“Хичээнгүй гэлэн Дамбадаржаа, Намсрай гэлэн, Гунгаажамц гэлэн, Лувсаншарав гэлэн, Гунгаа гэлэн, Дамдинжав гэлэн, Хайдав, Цүлтэмпунцаг гэлэн, Осор гэлэн, Ядамсүрэн гэлэн, Лүнриг гэлэн, Гончиг гэлэн, Чогсомдорж гэлэн, Цүлтэм гэлэн, Дашдондов гэлэн, Шарав гэлэн, Балдандорж, Жамьяан, Жайдүв, Жимба, Гэмпэл гэлэн, Гонгоржав гэлэн, Лувсанцэрэн гэлэн, Түмэнжаргал, Цүлтэм гэлэн, Агваан, Пэрэнлэй, Зундуй гэлэн, Лувсанбалдан, Чойдог гэлэн, Дэлэг, Хайдав, Гомбожав гавж, Чимэддорж, Гонгор гэлэн, Дамба (тө. brtan pa), Баяр, Даржаа, (fol. 253)

Чоймбэл, Дондов, Даваа, Чоймбэл, Данзан, Чоймчог, Гэлэг-Ёндон, Гуржав, Ганжуур, Гомбожав, Тавхай, Магсар, Сандуй, Жамбал, Дондов, гэх мэт.”

Сийлбэрчид

Гарчгаас харахад сийлбэрчдийн (тө. *rag bkos pa ro*) нэрсийг тодорхой дурдсан байдаг. Харин тэд өөрсдөө хэвлэж байсан эсэхийг сайн судлах хэрэгтэй байна.

“Сэрээтэр, Зундуй, Намсрай, Дамдинсүрэн, Пэлжээ, Жимба, Гончиг, Лувсан, Балдан-Осор, Мөнхдорж, Дондовдорж, Дамдин, Лувсангэндэн, Жалсрай, Лувсанбалдан, Доржсүрэн, Гэлэнхүү, Чогсом, Ням-Осор, Лувсанцүлтэм, Намжил, Цэрэндондов, Агваан, Пунцагдорж, Данзан, Чойжин, Намсрай, Балдан, Цэрэндондов, Лувсангомбо, Дорж, Шарав, Лувсан, Зэвэг, Хас, Дондов, Цэнд, Базаржав, Цүлтэм, Агваан, Дэмбэрэл, Дондов, Гончигдамба, Лхамсүрэн, Чоймаа, Дансүрэн, Дамба гэлэн, Дов, Мөнхцогт, Лосол, Маналжав, Батсуурь, Жигжид, Дагважамц, Чойжамц, Гончиг, Сономпунцог, Балжинням, Дамбий, Ядамжав, Чойжоо, Сосор, Сэрсүм, Банзрагч, Аюурзана, (fol. 254) Цэрэндорж, Гарам, Срүмба (тө. *srin pa*), Бат-Орших, Дэмчиг, Цүлтэм, Шагдаржамба, Ламжав, Гэндэн, Данзан, Дамбий, Жигмэд, Дугар, Тавхай, Ишжамц, Шийравжамц, Гончигжамц, Дамбаринчен, Гэндэн, Дамбадаржаа, Цүлтэм, Лувсанжимба, Дондовжамц, Гэлэг-Ёндон, Гэлэгжимба, Дагвадорж, Ишдорж, Ишжамъян, Дамбадорж, Цэрэнжав, Цэрэндорж, Жамбал, Соном, Дамчой, Дэмид, Гунгаадондов, Жалцансамбуу, Дэмбэрэл, Ширавчогдон, Шаравчогдүв, Төмөр, Самдан, Дэмчиг, Дамба (тө. *bden pa*), Дамчой, Сүмбэр, Сугар, Дэмпил гэх мэт.”

Дүгнэлт

Хүрээ барын Ганжуур нь 20-р зууны эхэн үеийн монгол лам нар шашны өндөр боловсрол эзэмшсэнийг харуулж байна. Гуравхан жилийн дотор ийм том бүтээлийг хийж бүтээсэн нь үнэндээ гайхамшиг юм. Гарчигт дурдсан лам, хар хүмүүсийг судлах нь Монгол улсын түүх, Монголын бурханы шашны түүхэнд чухал ач холбогдолтой юм. Их хүрээний түүхийн хувьд ялангуяа Д.Дамдинсүрэнгийн бичсэн “Их хүрээний нэрт урчууд” хэмээх номтой харьцуулвал тухайн үеийн бурханч, сийлбэрчдийн нэрс нь тодорхой болно.⁴⁶⁰

20-р зууны эхэн үеийг үзвэл Богдын хүрээний түүхэнд чухал үйл явдал ихээхэн тохиолдсон байдаг. Заримаас нь дурдвал, Хүрээ барын Ганжуурыг Богд хааны ногоон сүм (1893–1903), Чойжин ламын сүм барьсны (1904–1908) дараа, Богд хааныг хаан ширээнд залж, Идгаачойнзинлин дацан (1911 он), Жанрайсэгийн сүм (1913 он), Жүгдэрийн Хүрээний зураг (1912

⁴⁶⁰ Дамдинсүрэн, Д.: *Их хүрээний нэрт урчууд*. Монголпресс, Улаанбаатар 1995.

он) зурахаас өмнө бүтээсэн нь тодорхой байна. Сийлбэрчдийн хувьд зарим нь 1924 онд Дүйнхорын лойлонг бүтээх ажилд ч оролцож байсан байдаг.⁴⁶¹

Харин одоохондоо тодорхойгүй асуултууд гэвэл, Хүрээ барын Ганжуураас хэдэн хувийг хаана бүтээсэн бэ? Дарба бандида гэгээнтэн, бусад гавж нар хаана, аль дуганд хэрхэн хамтран ажилласан бэ? Бүтээгдсэн Хүрээ барын Ганжуурыг аль дуганд залдаг байсан бэ? Хүрээ барын Ганжуурыг хөдөөний хийдүүд хэр их аваад явсан бэ? Данжуурыг бас бичиж эхэлсэн үү, үгүй юү зэрэг асуултуудыг судлах хэрэгтэй байна.

Өнөөгийн Улаанбаатар хотод бүтээгдсэн Ганжууруудаас Хүрээ барын Ганжуураас гадна сүүлийн үед Монгол Ганжуур, Данжуурыг хөрвүүлж буй Цогт цагийн хүрдэн соёлын төвийн эрдэмтэн лам, судлаач нарын ажлыг заавал дурдах хэрэгтэй. Кирил үсгийн Ганжуур, Данжуурын 70 хувь одоо нэгэнтээ бэлэн болжээ. Бурхан Багшийн айлдварыг дамжуулахад энэхүү хөрвүүлж буй бүтээл нь одоогоор хамгийн сүүлчийн бүтээл болж байна. Судлаач нар кирил үсгийн Ганжуур, Данжуурыг хэн, яаж, ямар хандиваар бүтээснийг Хүрээ барын Ганжуурын адил судлах болно гэдэгт итгэж байна.

Ном зүй

Bethlenfalvy, Géza: *A Catalogue of the Urga Kanjur in the Prof. Raghuvira Collection at the International Academy of Indian Culture*. (Śata-piṭaka Series 246) International Academy of Indian Culture, New Delhi 1980.

Дамдинсүрэн, Д.: *Их хүрээний нэрт урчууд*. Монголпресс, Улаанбаатар 1995.

Lokesh Chandra: *A Newly Discovered Urga Edition of the Tibetan Kanjur*. *Indo-Iranian Journal* 3. New Delhi 1959, pp. 175–204.

Lokesh Chandra (ed.): *Urga Kanjur*. Vols. 1–105. (Śata-piṭaka Series 396–500) International Academy of Indian Culture and Aditya Prakashan, New Delhi 1900–1994.

Lokesh Chandra (ed.): *Urga Kanjur*. Vols. 104–105. (Śata-piṭaka Series 499–500) International Academy of Indian Culture and Aditya Prakashan, New Delhi 1994.

Сэрээтэр, Ө.: *Монголын Их хүрээ, Гандан хийдийн түүхэн бүтцийн товч. 1651–1938 он*. Адмон, Улаанбаатар 1999.

Teleki, Krisztina: *Introduction to the Study of Urga's Heritage*. Mongolian Academy of Sciences, Institute of History and Archaeology – International Association for Mongol Studies. Ulaanbaatar 2015.

⁴⁶¹ Дамдинсүрэн, Д.: *Их хүрээний нэрт урчууд*.

